СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ




# ЮНЕСКО-гийн “2003 оны Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцийн хэрэгжилтийн хугацаат тайлан

## 2017/12/15-2024/06/15,

## 2024/12/15

СӨҮТ, Авран хамгаалах эрсдэлийн судалгааны газрын СББӨ-ийн
шинжээч О.Цэвэлмаа

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Агуулга

- Хугацаат тайлан гэж юу вэ?
- Хугацаат тайлангийн ICH-10 маягтын бүтэц
- Асуултанд хариулах зарчим
- ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн өвүүд
- Хуваарь

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## 2003 оны конвенцийн хугацаат тайлан

- ЮНЕСКО-ийн “Хүн төрөлхтөний СББӨ-ийн Төлөөллийн жагсаалт”-д бүртгэгдсэн өвийн элементүүдийг хамгаалах үүргийг Монгол Улсын Засгийн газар “**СББӨ-ийг хамгаалах 2003 оны конвенци**”-ийн өмнө хүлээдэг. Энэхүү үүргийн хүрээнд тус конвенцийн биелэлтийн **хугацаат тайлан**г 6 жил тутамд илгээдэг бөгөөд энэ нь Ази, Номхон далайн бүс нутгийн орнууд 2024 оны 6 дугаар сарын 15-нд “Урьдчилсан тайлан”, 2024 оны 12 дугаар сарын 15-нд тайланг сүүлийн байдлаар илгээнэ.

## Хорооноос тогтоосон маягтын дагуу тайлан ирүүлэх хатуу үүрэг (29-р зүйл)

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

# Үндэсний хэмжээнд хугацаат тайлагналтын боломжит ашиг тус

- Салбар хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, конвенцийг тайлагнах, хэрэгжүүлэхэд ТББ/ИНБ-ын оролцоог бүх цаг үед дэмжих боломжтой.

- Төрийн янз бүрийн агентлагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, мэргэжилтнүүд зэрэг хамгааллын төлөөх олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс болон бусад оролцогч талуудын хоорондын харилцааг хөгжүүлэхэд тусалж чадна.
- Аймгууд СББӨ-ийн УНБМСан болон өөрсдийн өвийн онцлогт тулгуурлан мэдээллээ бүрдүүлж илгээнэ.

Дэлхийн өвийн **“Төлөөллийн жагсаалтанд бүртгэгдсэн СББӨ”**-ийн хугацаат тайлан нь **ICH-10** тоот маягтаар илгээддэг бөгөөд дээрх хүснэгт нь тухайн маягтын ерөнхий бүтэц болно. Нийт 8 дэд сэдвийн 26 үзүүлэлтээр Монгол Улсаас бүртгэгдсэн өвийн элементийн өнгөрсөн 6 жил дэх **суурь түвшин** болон дараагийн тайлант хугацаан дах **хүрэх түвшин**г тодорхойлно.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ICH-10 маягтын бүтэц

| | |
|---|---|
| А бүлэг | Ерөнхий мэдээлэл |
| В бүлэг | Хамгийн гол хэсэг буюу 8 дэд сэдэв, 26 үзүүлэлт, 84 асуулт (21 аймаг, ТББ, бусад оролцогч талуудын конвенцийн хэрэгжилт дэх оролцооны үр дүн)<br>СББӨ-ийн талаар авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээ |
| С бүлэг | Төлөөллийн жагсаалтанд бүртгэгдсэн элементүүдийн тус бүрээр асуултуудын дагуу хариулна (7 асуулт) |
| D бүлэг | Баталгаажуулах хэсэг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нөлөөлөл** | Соёлын биет бус өв нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсээр хамгаалагдах нь түүнийг тасралтгүй хамгаалж, улмаар энх тайван, хүртээмжтэй нийгэмд хүний сайн сайхан, нэр төр, бүтээлч байдлын төлөө тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг. | | | | | | | |
| **Урт хугацааны үр дүн** | Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг бэхжүүлэх | | Соёлын биет бус өвийн олон янз байдлыг хүндэтгэдэг. | | Соёлын биет бус өвийг хүлээн зөвшөөрч, танин мэдүүлж, хамгаалах | | СББӨ-ийн хамгаалалтын төлөөх оролцоо, олон улсын хамтын ажиллагаа бүх түвшний оролцогч талуудын дунд нэмэгдэнэ. | |
| **Дунд хугацааны үр дүн** | Соёлын биет бус өвийн тодорхой элементүүдийг хамгаалах арга хэмжээ, төлөвлөгөөг олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсээр удирдуулсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэнэ. | | | | | | | |
| **Богино хугацааны үр дүн** | Соёлын биет бус өвийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх чадавхийг ерөнхийд нь сайжруулна.<br>СББӨ-ийн тодорхой элементүүдийг хамгаалах арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулна. | | | | | | | |
| **Дэд сэдвүүд** | Байгууллага болон хүний нөөцийн чадавхи | СББӨ-ийг дамжуулах болон боловсрол | Бүртгэл, судалгаа | Бодлого, хууль эрх зүйн орчин болон захиргааны арга хэмжээ | СББӨ-ийн үүрэг, түүний нийгэм дэх хамгаалалт | Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх | Хамт олон, бүлэг, хувь хүмүүс болоод бусад оролцогч талууд | Олон улсын хамтын ажиллагаа |

Үзүүлэлтүүд(26)

Үнэлгээний хүчин зүйлүүд (86)

} 4 бүлэг, 8 дэд сэдэв

# Маягтын A, B, C хэсгүүдийн хоорондын хамаарал



# Оролцогч талууд



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# “B” бүлгийн 8 дэд сэдэв 26 үзүүлэлтүүд

## Бүсийн хэмжээн дэх бүх СББӨ-ийн хүрээнд

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 1: Байгууллага ба хүний нөөц

## Үзүүлэлт 1

СБӨ-ийн цаашдын практик болон өвлүүлэн уламжлуулах үйл явцад эрх бүхий этгээд болон байгууллагууд хэрхэн дэмжлэг үзүүлдэг тухай

Хамгаалах шатны байгууллагын чадавхид анхаарлаа хандуулна

## Үзүүлэлт 2

СББӨ-ийн хамгаалалт, менежментийг дэмжих боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр байдаг эсэх

СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр дунд боловсролын дараах сургалтад анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 3

Хамт олон, бүлэг, хувь хүн, соёлын өвийн салбарт ажиллаж байгаа хүмүүст сургалт явуулдаг эсэх

Ийм сургалтанд хамрагдсан хүмүүст анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 2: Өвлөн уламжлуулалт ба боловсрол

## Үзүүлэлт 4

Албан болон албан бус боловсролын аль аль нь СББӨ-ийн өвлүүлэн уламжлуулалтыг бэхжүүлж, СББӨ-ийг хүндэтгэхийг дэмждэг эсэх

СББӨ-ийн боловсрол нь түүнийг хүндэтгэх, хэрэгжүүлэх, дамжуулахад үзүүлсэн нөлөөлөлд анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 5

СББӨ болон түүний хамгаалалтыг бага, дунд боловсролд нэгдсэн, холбогдох хүмүүжлийн агуулгад багтаан СББӨ-ийн тухай болон түүнтэй хамт заах, суралцах, өөрийн болон бусдын СББӨ-ийг хүндэтгэх багшлах, суралцахыг бэхжүүлэхэд ашигласан байдал

Бага, дунд шатны боловсролд анхаарал хандуулна.

## Үзүүлэлт 6

Дунд сургуулийн дараах боловсрол нь СББӨ-ийн практик, дамжуулалтыг дэмжихийн зэрэгцээ нийгэм, соёлын болон бусад чиглэлүүдийг судлахад дэмжлэг үзүүлдэг байдал

Дунд сургуулийн дараах шатны боловсролд анхаарал хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 3: Бүртгэл ба судалгаа

## Үзүүлэлт 7

Бүртгэл нь СББӨ-ийн олон янз байдлыг тусгаж, түүний хамгаалалтанд хувь нэмрээ оруулдаг эсэх тухай

Бүртгэлжүүлэлт болон түүнийг хамгаалалтанд хэрхэн ашигладаг талаар анхаарах

## Үзүүлэлт 8

Бүртгэлийн үйл явц нь СББӨ болон түүний өвлөн уламжлагч нарын олон талт байдлыг хүндэтгэж, холбогдох олон нийт, бүлэг, хувь хүмүүс хамгаалалтыг дэмждэг эсэх тухай.

Бүртгэлийн үйл явцын хүртээмжтэй байдалд анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 9

Хамгаалах үйл ажиллагаанд судалгаа болон баримтжуулалт түүнчлэн шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа зэрэг нь хувь нэмэр оруулдаг эсэх.

Судалгаа, баримтжуулалтын үйл явцад анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 10

Судалгааны үр дүн, баримтжуулалтыг хүртээмж, бодлого боловсруулалтыг бэхжүүлэх, хамгаалалтыг сайжруулахад ашигладаг эсэх

Судалгааны үр дүн, баримт бичиг, тэдгээрийн хэрэглээнд анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 4: Бодлого, хууль эрх зүйн орчин ба захиргааны арга хэмжээ

## Үзүүлэлт 11

Соёлын салбарын бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнд СББӨ-ийн олон талт байдал, түүнийг хамгаалахын ач холбогдлыг тусгаж, хэрэгжүүлдэг эсэх.

Соёлын салбарын бодлогод анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 12

Боловсролын салбар дахь бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон талт байдал, түүнийг хамгаалахын ач холбогдлыг хэр тусгаж, хэрэгжүүлж байна вэ?

Боловсролын салбарын бодлогод анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 13

Соёл, боловсролоос бусад салбар дахь бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон талт байдал, түүнийг хамгаалахын ач холбогдлыг тусган хэрэгжүүлдэг эсэх.

Боловсролын салбарын бодлогод анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 14

Бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ нь зан заншлын эрх, зан үйл, илэрхийллийг ялангуяа СББӨ-ийн дадлага, дамжуулалтын талаар хэр хүндэтгэдэг вэ?

Бодлого дахь заншлын эрх, зан үйл, илэрхийлэлд хүндэтгэлтэй хандахад анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 5: Соёлын биет бус өвийн үүрэг ба нийгэм дэх түүний хамгаалалт

## Үзүүлэлт 15

СББӨ болон түүнийг хамгаалахын ач холбогдлыг холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс болон нийгэм даяар хүлээн зөвшөөрдөг эсэх.

СББӨ нь тогтвортой хөгжил, хүний сайн сайхан байдалд хэрхэн хувь нэмэр оруулсан талаар анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 16

Өөрийгөө хүндэтгэх, бие биенээ хүндэтгэх цогц төлөвлөгөө, хөтөлбөрөөр дамжуулан СББӨ-ийг хамгаалахын ач холбогдлыг хэр зэрэг хүлээн зөвшөөрч байна.

СББӨ-ийг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн хүртээмжтэй байдал, үр дүнтэй байдалд анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 6: Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

## Үзүүлэлт 17

Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд хэр өргөнөөр оролцож байгаа эсэх.

Иргэдийн оролцоо, тэдний эрх ашгийг хамгаалахад гарсан үр дүнд анхаарна.

## Үзүүлэлт 18

СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэгийг дээшлүүлэх, харилцан ойлголцол, харилцан хүндэтгэлийг дэмжихэд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд оролцдог эсэх.

Хэвлэл мэдээлэл, медиа салбарын үүрэг оролцоонд анхаарал хандуулна.

## Үзүүлэлт 19

Олон нийтэд мэдээлэл өгөх арга хэмжээ нь СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх ойлголтыг нэмэгдүүлж, харилцан ойлголцол, харилцан хүндэтгэлийг бий болгодог эсэх.

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээний агуулга, зорилго, үр нөлөө, үр дүнд анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 20

СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд холбогдох ёс зүйн зарчмуудыг хүндэтгэдэг эсэх.

Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ёс зүйн зарчмуудыг хүндэтгэх тал дээр анхаарна.

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 7: Хамт олон, бүлэг, хувь хүн болоод бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа

## Үзүүлэлт 21

Оролцогч талуудын дунд СББӨ-ийг хамгаалах оролцоо нэмэгдэж байгаа эсэх.

СББӨ-ийг хамгаалах үйл ажиллагаанд аль болох өргөнөөр оролцоход анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 22

СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад иргэний нийгэм хэр зэрэг хувь нэмэр оруулдаг эсэх.

СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг хянахад янз бүрийн оролцогч талуудын оролцоог хангах орчныг бүрдүүлсэн эсэхэд анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Дэд сэдэв 8: Олон Улсын хэмжээний хамтын ажиллагаа

## Үзүүлэлт 23

Хорооноос зөвлөх, зөвлөхөөр оролцдог төрийн бус байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүсийн тоо, газарзүйн тархалт (энэ үзүүлэлтийг Дэлхийн хэмжээнд Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газраас хянаж, тайлагнадаг)

ТББ, мэргэжилтнүүдийн үүрэгт анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 24

Хамгаалалтын чиглэлээр бусад оролцогч улстай идэвхтэй хамтран ажиллаж буй оролцогч улсуудын хувь нэмэр.

Оролцогч улс орнуудын албан ёсны хамтын ажиллагаанд анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 25

Олон улсын сүлжээ, институцийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож буй оролцогч улсуудын хувь нэмэр.

Оролцогч улс орнуудын институцийн болон шинжээчдийн хамтын ажиллагаанд анхаарлаа хандуулна.

## Үзүүлэлт 26

- Соёлын биет бус өвийн сан нь хамгаалалт, олон улсын оролцоог үр дүнтэй дэмждэг (энэ үзүүлэлтийг дэлхийн түвшинд Нарийн бичгийн дарга нарын газраас хянаж, мэдээлдэг).

СББӨ-ийн сангийн үүрэгт анхаарлаа хандуулна.

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

# Асуултанд хариулах зарчим

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

- ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтанд бүртгэгдсэн өвүүдийн талаар хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл, тайлан, тоон дүнг хамруулан бичнэ.
- Асуулт тус бүрт заавал хариулна.
- Асуулт бүр тийм/үгүй болон хэмжүүр илэрхийлсэн хариулттай өгөөд, хэрэв “тийм” гэсэн хариултыг сонгосон тохиолд заавал дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Үүнд

  - зохион байгуулсан арга хэмжээний нэр,

  - тушаал шийдвэр,

  - зохион байгуулагдсан газар,

  - оролцсон хүний тоо,

  - өвлөн уламжлагч нарын тоо зэрэг заавал нотлох баримттай байхыг анхаарна уу.

**Асуулт 7.1.а**

А.6-р хэсэгт тодорхойлсон бүртгэлийн байдал ямар хэмжээнд байна вэ?

/сонгох/

Маш сайн

Сайн

Дунд

Бага

Муу

Бүртгэл нь СББӨ-г хамгаалахад хэрхэн чиглэгдсэнийг товч тайлбарлана уу. Хэрэв та “Бага” эсвэл “Муу” гэж хариулсан бол бүртгэл хийхэд ямар саад бэрхшээлтэй тулгарч байгаагаа тайлбарла.

2017-2021 онуудад Хөвсгөл аймгийн Засаг даргын ... тоот захирамжаар Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа өвлөн уламжлагч нарыг бүртгэх, таниж тогтоох ажлыг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн ..... сумын ..... өвлөн уламжлагчдыг алдаршуулж, .... өвлөн уламжлагчдыг шинээр бүртгэв. Хөвсгөл аймгаас бүртгэгдсэн өвлөн уламжлагчдыг ангилан үзэхэд ... хувь “Ардын язгуур урлаг”, … хувь нь “Уламжлалт арга ухаан, технологи”, … хувь нь “Байгаль сав шим, ертөнцийн тухай мэдлэг”, … хувь нь “Уламжлалт гар урлал”, … хувь нь “Уламжлалт баяр наадам, тоглоом наадгай”, .. хувь нь “Эх хэл, аман уламжлал” зэрэг ай савуудад бүртгэгдсэн үзүүлэлт байна. Нийт төсөв ....

Үгийн тоо 0 < 0 < 300

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

## Арвандолдугаар хэсэг

Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд хэр өргөнөөр оролцож байгаа эсэх.

Асуулт 17.1

Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаа нь холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн аль болох өргөн, хүртээмжтэй оролцоог хангаж байгаа уу?

/сонгох/

Тийм

Үгүй

Оролцоо хэрхэн хангагдаж байгааг жишээгээр товч тайлбарлана уу. Хэрэв тийм биш бол шалтгааныг тайлбарлана уу.

СББӨ-ийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дорнод аймаг нь 20.. оны ... сарын ...-ны өдөр тус аймгийн хэмжээнд “СББӨ-ийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өвлөн уламжлагчыг алдаршуулах” “……..” нэртэй арга хэмжээ зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд “УНБМС-д бүртгэгдсэн ... өвлөн уламжлагчын ... нь оролцов. Үүний .. буюу ... хувь нь хамрагдав.” Нийт төсөв.....

Үгийн тоо 0 < **0** < 300

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

**Асуулт 18.2**

СББӨ-ийн янз бүрийн оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран СББӨ-тэй холбоотой тодорхой хамтын ажиллагааны арга хэмжээ, хөтөлбөрүүдийг, тэр дундаа чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг бий болгож хэрэгжүүлдэг үү?

/сонгох/

Тийм

Үгүй

1. Архангай аймгийн Засаг даргын ... Тоот тушаалаар аймгийн СУГ, ...., ..... Сумдын Соёлын төвүүд “........” телевизтэй хамтран 20.. Оны .. Сарын ..-ны өдөр “........”цэнгээнт нэвтрүүлгийг зохион байгуулав. Тус нэвтрүүлэгт ….. СББӨ-ийн … өвлөн уламжлагч оролцож, ….. Иргэд оролцов. Тус нэвтрүүлгийг …., …., …., сувгаар нийт …. Удаа олон нийтэд цацав.
2. Завхан аймгийн “Уламжлалт гар урлал” ай савд хамаарах СББӨ-ийн өвлөн уламжлагчдийн “........” нэртэй ТББ-ын хөтлөдөг албан ёсны “.........” фейсбүүк пэйж хуудсанд “.........” нэртэй тухайн өвийг хамгаалах, сурталчлах, зарим нэг өвийн төрлийг үйлдэх тухай видео хичээл ..... удаагийн давтамжтай олон нийтэд нийтэлсэн байна.

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

## Асуулт 13.2

Нийгмийн хүртээмжтэй хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангах бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээнүүд нь СББӨ болон түүний хамгаалалтыг харгалзан үзсэний үндсэн дээр бий болсон уу?

/сонгох/

Тийм

Үгүй

Өмнөговь аймгийн СУГ, Байгаль орчин аялал жуулчлалын газрын хамтыг ажиллагааны .... тоот санамж бичгийн дагуу "Говийн бүсийн хөрс хамгаалах" тухай сургалт 20... оны .. сарын...-ээс ..-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус арга хэмжээнд говийн хөрсний онцлог, цаашид тогтвортой хадгалахын тухай "Уламжлалт арга ухаан"-ыг "Байгаль сав шим, ертанцийн тухай мэдлэг" ай савд хамаарах өвийн .... Өвлөн уламжлагчид өөрсдийн туршлага, үе дамжсан арга ухаанаа аймгийн нийт.. ард иргэд, .... сурагчид, .... байгаль хамгаалагчид зэрэгт хуваалцав. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас судалгааны үндсэн дээрх мэргэжлийн зөвлөгөө танилцуулав. Тус арга хэмжээний нийт төсөв ...төгрөг.

СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Зэрэг заавал тоон мэдээ факт буюу үр дүнд суурилсан мэдээлэл өгөхийг анхаарна уу.

Манай улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцийн Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад дараах 15 өвийг бүртгүүлсэн.

2024 оны хугацаат тайлангийн C хэсэгт хамаарах өвүүд

# ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад:

- Морин хуур хөгжмийн уламжлал турлаг 2008
- Монгол ардын уртын дуу 2008
- Монголын уламжлалт Хөөмэйн урлаг 2010
- Шувуучлахуй буюу Бүргэдээр ан хийх зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) 2010
- Монгол баяр наадам 2010
- Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл 2013
- Монгол шагайн харваа 2014



# Анхаарал хандуулсанд баярлалаа.

Viber: +976 99183898
Email: tsevelmaa@ncch.gov.mn
tsevelmaa.ot@gmail.com